

ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН "ХҮНИЙ ХӨГЖИЛ" БҮЛГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

№	Бодлогын үндэслэл	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хэрэгжилт, хүрсэн түвшин	Хэрэгжилт ийн хувь	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэл ийн хувь	Хариуцах байгууллага	
					он	Түвшин							Үндсэн	Хамтран
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО														
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн														
Эрүүл мэнд														
1	АХ-1.1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, сумын хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийн нэмэгдүүлэх замаар сумын хүн амын дундаж наслалтыг аймгийн зорилтот түвшинд хүргэнэ.	Хүн амын дундаж наслалт	Жилээр	2024	74.62	75	Сумын хүн амын дундаж наслалт 75.01 байна.	100.00	-	-	-	ЭМТ	ЗДТГ
Хөтөлбөрийн үр дүн														
Эрүүл мэнд														
2	АХ-1.1.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт	Хувь	2024	43.2	50.0	2025 оны 6 дугаар сарын байдлаар эрт илрүүлгийн хамрагдалт 29.5 хувьтай байна.	50	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Хамрагдсан иргэд	Тоо	2024	1345	1450	Тайлант хугацаанд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 700 иргэн, сайн дурын дархлаажуулалтад 75 иргэн хамруулаад байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 1911 иргэнийг хамруулахаас тайлант хугацаанд 565 иргэдийг хамруулж, хамрагдсан иргэдийн эзлэх хувь 29.5 байна. Элэгний В вирусн сайн дурын дархлаажуулалтад 17-73 насны 75 иргэнийг хамруулаад байна.	50	-	-	-	ЭМТ	ЗДТГ
3	АХ-1.1.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	Түвшин	2024	25.9	25.4	Зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 1 тохиолдож, нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ 0.3 хувьтай байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Хорт хавдар өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	Түвшин	2024	14.1	13.1	Хорт хавдар өвчний шалтгаант нас баралт 1 тохиолдож, нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/ 0.3 хувьтай байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	Промиль	2024	0	0	2025 оны хагас жилийн байдлаар эхийн эндэгдэл гараагүй.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Нялхсын эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/	Промиль	2024	9.0	8.9	2025 оны хагас жилийн байдлаар нялхасын эндэгдэл гараагүй.	100	-	--	-	ЭМТ	ЗДТГ
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/	Промиль	2024	21.1	21.0	2025 оны хагас жилийн байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гараагүй.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэд	Тоо	2024	9850	10000	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй 13 арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүд, нэрэмжит сарын аянуудыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хариуцуулан өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 7665 иргэдэд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, Дашинчилэн эрүүл мэндийн төв фэйсбүүк хаягаар зөвлөмж, мэдээллийг дамжуулан 7980 хүний хандалт авсан байна.	90	-	-	-	ЭМТ	ЗДТГ
4	АХ-1.1.3	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна.	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Тоо	2024	4	5	Мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн 4 байна. Энэ онд мэргэжлийн зэргийн шалгалтанд орохоор 3 эмч, мэргэжилтэн материалаа бүрдүүлж Хөгжлийн төвд хургуулсан.	80	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			10.000 хүн амд ногдох сувилагчийн тоо	Тоо	2024	13.5	13.5	Сумын эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартад заагдсан орон тоогоор ажиллаж байна. 10.000 хүн амд ногдох сувилагчийн тоо 13.5 байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Нэг эмчид ногдох үйлчлүүлэгчийн тоо	Тоо	2024	585	540	2025 оны 6 дугаар сарын байдлаар 2 их эмчийн орон тооны дутагдалтай, нэг эмчид ногдох эмчлүүлэгчийн тоо 1480 байна.	50	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны тоо	тоо	2024	2	4	Сувилагч Б.Нарангэрэлийг Улаанбаатар хотод мэргэшүүлэх 3 сарын сургалтад хамруулж, сургалтын зардал болон сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгоод байна.	90	290 мянга	290 мянга	100	ЭМТ	ЗДТГ
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа														
Эрүүл мэнд														

5	АХ-1.1.1.1	Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Сургалтад хамрагдсан иргэд	тоо	2024	9850	10000	Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй 13 арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүд, нэрэмжит сарын аянуудыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хариуцуулан өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 7665 иргэдэд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, Дашинчилэн эрүүл мэндийн төв фэйсбүүк хаягаар зөвлөмж, мэдээллийг дамжуулан 7980 хүний хандалт авсан байна.	90	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт	Хувь	2024	43.2	50	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 29.5 хувь байна. Цаашид иргэдийн эрт илрүүлэгт хамруулж хамрагдалтын хувийг нэмэгдүүлэхээр эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулж байгаа мэргэжлийн төвүүдтэй хамтарч ажиллахаар төлөвлөж байна. Иргэдийг даатгалд хамруулах талаар БЗД, Багийн эмч нартай хамтарч ажиллаж байна.	50	-	-	-	ЭМТ	ЗДТГ
6	АХ-1.1.1.2	Хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.	Зүрх судасны тогтолцооны өвчлөл	Промиль	2024	3726.7	3720.2	ЭМТ-д цусны даралт ихсэх эмгэгтэй 215 иргэн, зүрх судасны эмгэгтэй 34 иргэн хянагдаж байна. Хүн амын дундах зонхилон тохиолдох зүрх судасны тогтолцооны өвчлөл 1239 промиль байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл	Промиль	2024	1790.2	1789.2	Одоогоор элэгний В вирустай 54, С вирустай 125, элэгний В, Д вирустай 14 иргэн байна. В вирусны эмийн эмчилгээнд 6 иргэн хамрагдаж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 10000 хүн амд харьцуулахад 297 промиль байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Хожуу үедээ оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эзлэх хувь	хувь	2024	49.6	44.1	Тайлант хугацаанд 5 иргэн хорт хавдараар ношлогдсоноос 3 иргэн буюу 60 хувь нь хожуу үедээ оношлогдсон.	50	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Осол гэмтлийн өвчлөл	Промиль	2024	161.0	141.0	2025 оны эхний хагас жилд осол гэмтлийн өвчлөл 18 бүртгэгдэж, 60.8 промиль байна.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
			Сүрьеэгийн өвчлөл	Өвчлөлийн түвшин	2024	4	3	2025 онд эмэнд дасалтай сүрьеэгийн 1 тохиолдол бүртгэгдэж, ХӨСҮТ-д эмийн эрчимт эмчилгээнд хамруулж байна. Сүрьеэгийн уг тохиолдлын хавьтал болох 6 хүнийг сүрьеэгийн эмчийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан.	100	-	-	-	ЭМТ	ЗДТГ
7	АХ-1.1.1.1	Өвчлөл нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	Тоо	2024	-	2	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Эрүүл мэнд, Боловсролын сайдын хамтарсан тушаалын хүрээнд "СУРГУУЛЬД СУУРИЛСАН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ"-ийг эхлүүлээ. Үзлэгт Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагч шүд, нүд, зүрх гэсэн гурван төрлөөр эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж оношилгоо, эмчилгээг хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн эмч Ц.Оюунжишиг нүдний эмгэг илрүүлэх үзлэгийг тусгай хэрэглэгдэхүүний тусламжтайгаар хийж, өөрчлөлттэй илэрсэн 4 хүүхдүүдийг нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд шилжүүлсэн. Шүдний эмч Б.Оюундамба, шүдний туслах ажилтан Ө.Эрдэнатуяа нар шүдний үзлэгийг зохион байгуулж, эмчилгээ шаардлагатай 50 хүүхдүүдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Зүрхний эмгэг илрүүлэхээр цахилгаан бичлэг хийж, зүрхний нарийн мэргэжлийн эмч нарт өөрчлөлттэй илэрсэн 4 хүүхдийг илгээж, эмчилгээнд хамруулсан.	80	-			ЭМТ	ЗДТГ
8	АХ-1.1.2.1	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, барилга байгууламжид өргөтгөл хийх, стандартын шаардлагад нийцүүлнэ.	Барилга, байгууламжийн тоо	тоо	2024	1	1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ЭМЯ, Цонбон Тоосго ХХК, Модернхас ХХК-тай гэрээ байгуулж 5.6 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих ажлыг гүйцэтгэж, тайлант оны 09 сард ашиглалтанд өгөхөөр хүлээгдэж байна.	100	5.6 тэр бум	5.6 тэр бум	100	ЭМТ	ЗДТГ
			Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт	хувь	2024	90.0	92.0	ЭМТ-д Азийн хөгжлийн банкны төслийн хүрээнд Оношилгооны 40ш тоног төхөөрөмж, лабораторийн 12ш тоног төхөөрөмж, эмчилээний 29ш тоног төхөөрөмж, ариутгал, угаалга, гал тогооны 15ш тоног төхөөрөмж, бусад тавилга 19ш, бүгд 115 ш тоног төхөөрөмж нийлүүлэхээр жагсаалтаар ирсэн. ЭМТ-ийн барилга ашиглалтад ороход хүлээлгэн өгнө.	100.0	-	-	-	ЭМТ	ЗДТГ

[illegible]

13	АХ-1.2	Хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвөлсөн хүмүүнлэг ёс зүйтэй, өв тэгш иргэнийн төлөвшүүлнэ.	СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	2023	88.6	89.5	2024 онд СӨБ-ын дундаж үнэлгээ 90.82-иар үнэлэгдсэн. Тухайн жилийн дундажаас 2.2 хувиар өндөр үзүүлэлттэй байна.	100.0	-	-	-	ЕБС	ЗДТГ
		ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	2024	50.32	52.0	Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 05 сард зохих журмын дагуу зохион байгуулагдсан. Нийт 13 судлагдахууны 29 багш хамрагдсан. 2025 оны 09 сард үр дүн гарна	100.0	-	-	-	ЕБС	ЗДТГ	
Хөтөлбөрийн үр дүн														
Боловсрол														
14	АХ-1.2.1	Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэн, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бий болгоно.	Цэцэрлэгийн барилга байгууламжийн хүчин чадал	Ор	2024	115	130	115 хүүхдийн хүчин чадалтай 2 барилгатай	90	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн хүчин чадал	Суудлын тоо	2024	640	640	640 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн 1, 2 дугаар байртай.	100	50 сая	34 сая	68	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Сургуулийн дотуур байрны барилга байгууламжийн хүчин чадал	Ор	2024	75	150	75 хүүхдийн хүчин чадалтай хуучин дотуур байрны барилга, 150 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилга ашиглалтад орохоор хүлээгдэж байгаа.	90	3.7 тэр бум	3.7 тэр бум	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Тоног төхөөрөмжийн хангалт	Хувь	2024	75.0	80	ЕБС, цэцэрлэг, дотуур байрны тоног төхөөрөмжийн хангалт 80 хувьтай байна.	100	122.6	122.6	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж	Тоо	2024	2	5	Цэцэрлэгийн үндсэн барилга болон өргөтгөлийн барилга стандартад нийцсэн ариун цэврийн өрөөтэй, хэвийн ажиллагаатай, ЕБС-ийн хичээлийн 1, 2 дугаар байр ариун цэврийн өрөөтэй боловч ажиллагаа жигдрээгүй байна.	80	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
15	АХ-1.2.2	Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадвар, ёс зүйг дээшлүүлж, боловсон хүчний нөөц, нийгмийн баталгааг хангана.	Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	2023	88.02	89	1 дуу хөгжмийн багш, 5 бүлгийн багш, нийт 6 багш үнэлгээнд хамрагдсанаас 1 багш 3-р индекс, 5 багш 4-р индексээр үнэлэгдсэн.	80	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	Хувь	2024	50	55	Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 05 сард зохих журмын дагуу зохион байгуулагдсан. Нийт 13 судлагдахууны 29 багш хамрагдсан. 2025 оны 09 сард гүйцэтгэлийн үнэлгээний дүн гарна.	80	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Ёс зүйн чиглэлээр хийсэн ажлын тоо	тоогоор	2024	3	4	Байгууллагын ёс зүйн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, ёс зүйн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу “Эерэг хандлага түгээе” аяныг зохион байгуулж, 29 албан хаагчийгхамруулсан. Төрийн албан хаагчийн болон эцэг эх, асран хамгаалагчийн ёс зүйн чиглэлээр 2 удаагийн аян, 4 удаагийн өдөрлөгийг зохион байгуулсан. Мөн эцэг эх асран хамгаалагч нарт багшийн ёс зүйтэй холбоотой 130 ш тараах материалыг бэлтгэн хүргэсэн.	90	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Дэмжлэг урамшуулалд хамрагдсан албан хаагч, зарцуулсан хөрөнгө	Тоо, дүн	2024	8	10	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт албан хаагчдын 95 хувьд улирлын урамшуулал болон нэмэгдэл хөдсгийг тооцож олгосон байна.	100	37.8	37.8	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
						Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	Хувь	2024	507	509	2025 оны элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр дундаж оноо 495.50-тай байна	100	-	-
Бага боловсролын суралцагчдын монгол, хэл математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж	Хувь	2024				Математик- 54.4 Монгол хэл - 57.6	Математик- 56.4 Монгол хэл - 59.7	Математик судлагдахуун жилийн эцсийн дүнгээр 72.8 хувь, Монгол хэл 71.2 хувьтай үнэлэгдсэн. Зорилтот түвшиндээ хүрсэн.	100	-	-	-		
9 дүгээр ангийн сурагчдын унших чадварын дундаж	Хувь	2024				51	53	9 дүгээр ангийн сурагчдын унших чадвар оношлох үнэлгээгээр 51% үнэлэгдсэн бол жилийн эцсээр 53% болж өссөн байна.	100	-	-	-		
9 дүгээр ангийн сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж	Хувь	2024				30.2	33	9 дүгээр ангийн сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэл, оноглох үнэлгээгээр 30.2% үнэлэгдсэн бол жилийн эцсээр 33% болж өссөн байна.	100	-	-	-	ЕБС	ЗДТГ

16	1.2.3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сурагчдын сурлагын ахиц амжилтыг дээшлүүлнэ.	Багш, сурагчдын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт	Тоо	2024	-	50	ЕБС-ийн багш, сурагчид 2024-2025 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан эрэмжит болон төрөлжсөн олимпиадуудад амжилттай оролцлоо. Үүнд: Сансрын нисэгч Ж.Гуррагчаагийн нэрэмжит "САНСАР-44" хэлний XVI олимпиад Монгол хэлний төрөлд 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, Орос хэлний төрөлд 1 мөнгө, Англи хэлний төрөлд 1 хүрэл, АБТА, ахмад багш Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит химийн 22 дугаар олимпиадад 2 мөнгөн, 1 хүрэл, 1 тусгай байр, хамгийн олон шавь амжилттай бэлтгэсэн багшаар химийн багш Ц.Туул тус тус шалгарсан байна. Мөн Булган аймагт зохион байгуулагдсан Математикийн анхдугаар олимпиадад 1 алтан медаль авч, "Шилдэг багш"-аар М.Өсөхжаргал багш шалгарсан байна. Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд дизайн технологийн багш Э. Дондог хүрэл медаль, Нисэх загварын төрөлд 10а ангийн сурагч Г. Доржбат Хүрэл медаль хүртсэн байна. Монголын хүүхдийн спортын VIII-р наадмын "САМБО БӨХИЙН ТЭМЦЭЭН"-д Булган аймгийн Дашинчилэн сумын ЕБС-ийн Ж. Цогтбаатар багш дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцож, 4 алт, 3 мөнгө, 6 хүрэл медалийн эзэн болж, багийн нийлбэр дүнгээр 1-р байр эзэлсэн байна. Булган аймгийн классик пауэрлифтингийн 2025 оны аварга шалгаруулах, Монголын бүх ард түмний спортын наадмын сорилго тэмцээнд Ж.Цогтбаатар багштай баг тамирчид амжилттай оролцож, 4 алт, 14 мөнгө, 4 хүрэл медалийн эзэн болсон байна. Шүд угаалтын "Аймгийн аварга шалгаруулах" тэмцээнд 18 багийн 144 сурагчид оролцсоноос багийн нийлбэр дүнгээр Дашинчилэн сумын "Эрдэнийн чулуунууд" баг дэд байр, ганцаарчилсан төрөлд Ж.Урангуа тэргүүн байр эзэлсэн байна.	100	-	-	-	ЕБС	ЗДТГ
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа														
Боловсрол														
17	АХ-1.2.1.1	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрт шаардлагатай хөрөнгө оруулалтыг тусгуулж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.	ЕБС-ийн хамран сургалт	Хувь	2024	100	100	ЕБС-ийн хамран сургалтын хувь 100% байна.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			СӨБ-ын хамран сургалт	Хувь	2024	89	90	Байнгын бүлгийн хамран сургалт 86%, хувилбарт бүлгийн хамран сургалт 94%, цэцэрлэгийн хэмжээнд нийт хүүхдийн хамран сургалт 90%-тай байна	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсрол хамрагдалт	Хувь	2024	89.3	90.3	Сумын хэмжээнд ЕБС болон СӨБ-ын насны 10 хүүхэд байна. Үүнээс ЕБС болон цэцэрлэгт 9 хүүхэд хамрагдаж байна.	90	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
18	1.2.1.1	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэл, их засварын ажлыг хэрэгжүүлнэ.	Барилга, байгууламжийн тоо	тоо	2024	3	3	Шинээр цэцэрлэгийн 75 хүүхдийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг хийлгэсэн. ЕБС-ийн хичээлийн 1 дүгээр байранд 2025 оны эхний хагас жилд 50 сая төгрөгийн урсгал засварын ажлыг эхлүүлээд байна. Улсын төсвийн 3.7 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн ортой дотуур байрны барилга баригдаж, хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дотуур байрны барилгыг нэгдсэн халаалтад холбох сантехникийн засварын ажлын тендер зарлагдаж, гэрээг байгуулаад байна. ЕБС-ийн дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын төсвийг Боловсролын яаманд уламжлаал байна	70	80 сая	80 сая	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	хувь	2024	75.0	80	ЕБС 80 сая төгрөгийн өртөг лингафоны танхим шинээр байгуулах ажил хийгдсэн байна. Санхүү, бичиг хэргийн ажилтан, 9 багшид шаардлагатай байгаа 25,7 сая төгрөгийн өртөг бүхий 3ш суурин компьютер, 4ш хромбүүк, 4ш нотебүүкийг нөхөн хангалтын зардлаас нийлүүлсэн. Мөн биологийн хичээлийн дадлага ажилд ашиглах 5 сая төгрөгийн өртөг бүхий 2ш тасалгааны нарийн ногоо үрслүүлж тариалах төхөөрөмжийг авч сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хэсэгт 1,9 сая төгрөгийн үнэ бүхий хөлдөөгчийг авсан. Хүүхдийн цэцэрлэг нь 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар багш хөгжлийн тэнхимд ухаалаг дэлгэц, хэвлэгч, хувилагчийг худалдан авч, Мөн аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ Steam хөтөлбөрийн сургалтын хэрэглэгдэхүүнийг цэцэрлэгт хүлээлгэн өгсөн байна.	100	122.6	122.6	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж	тоо	2024	2	5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй "Гадна инженерийн шугам сүлжээ"-ний ажлын хүрээнд ЕБС-ийн барилгыг цэвэр усны шугамд 2025 онд холбуулахаар хүсэлтийг хөргүүлээд байна.	50	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ

19	1.2.1	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хөгжил, хамгааллын орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	2024	-	20	ОУХЭХӨ, Мөнгөн хонхны баярт зориулан Хойд бүсийн хэмжээнд зохион байгуулж буй "Мөрөөдлөөр жигүүрлэсэн хүүхэд насны дурсамжаа мөнхлөхүй" рийл видеоны уралдаанд 12А ангийн сурагчид нэгдэж, 2 дугаар байр эзэлсэн байна. Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд Дашинчилэн сумын ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчдад "Хүүхдийн хөгжил, төлөвшлийн цаг" хэмээх арга хэмжээг зохион байгуулан ажилласан. ЕБС-ийн хэмжээнд "Хүмүүн бичиг", Залуу байгальч, Юмханаар юм хийе, Залуу зохион бүтээгч зэрэг 12 төрийн дугуйлан хичээллэж, давхардсан тоогоор 100 гаруй сурагч хамрагдаж байна. Мөн "Дэвтэр бол сурагчийн толь" сарын аян, Дашинчилэн сум дахь эрэн хайх аврах бүлгийн үйл ажиллагаатай танилцах, явган аялал, ИТХ-ын даргын санаачилгаар ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын сум орон нутгийнхаа үзэсгэлэнт түүхэн дурсгалт газрыг үзэх танин мэдэхүйн аялал зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
20	АХ-1.2.2.1	Багш, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжиж, суралцагчийн хэрэгцээ шаардлагыг хангасан, цэцэрлэгийн бэлтгэл, хөгжлийн орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.	Сургалтанд хамрагдсан багш ажилчид	тоо	2024	83	110	ЕБС-ийн багш, ажилчид Боловсролын яам болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 25 төрийн албан хаагч, ажлын байран дээрх сургалтад 35 төрийн албан хаагч, багшийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад давхардсан тоогоор 42 төрийн албан хаагч хамрагдсан байна. Цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарын онол эрх зүйн болон мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор эрхлэгч, бүлгийн 5 багш, туслах 4 багш, тогооч нарыг улс, аймаг, бүсийн хэмжээнд зохион байгуулсан сургалтуудад 3-4 удаа хамруулж, сургалтын төлбөрт нийт 2013,1 мян/төгрөгийг зарцуулав. 2024-2025 оны хичээлийн жилд "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих - EQUAL" төслийн хүрээнд "Хосолсон сургалт"-ыг хэрэгжүүлэгч 85 сургуулийн нэгээр сонгогдож, бага ангийн 2 бүлэг, дунд ангийн 1 бүлэг дээр туршин ажиллаж байна. Уг төслийн хүрээнд "Өөрийн сайн туршлагаа багш нартаа түгээн дэлгэрүүлж, сурталчилсан байдал" төрөлд МХБУЗ-ын багш Б.Дуламсүрэн амжилттай оролцож, "ТУТГААР" байранд шалгарч, 4 сая төгрөгөөр шагнуулсан.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Туршлага судалсан багш, ажилчид	тоо	2024	5	10	Дотоодын туршлага судлах ажлын хүрээнд цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаа СӨБ-ын байгууллагуудын удирдах ажилтануудын хамт Дархан хотын цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай, арга зүйч О.Давааням аймгийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн ахлагч нарын хамт Орхон аймгийн 1,5,10 дугаар цэцэрэгийн үйл ажиллагаатай тус тус танилцсан. Мөн цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багш нарын 8 албан хаагч Булган аймгийн 7 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан байна. Туршлага судлах ажлын хүрээнд олж авсан сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ

		Чадварлаг багшийн бэлтгэл.	Багш нарын уралдаан тэмцээнд гаргасан амжилт	тоо	2024		Багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэх, сайн хичээл, сайн арга зүйг түгээн дэлгэрүүлэх, Сургалтын үйл явцыг шинэчлэх, интеграци хичээлийн ач холбогдлыг ойлгох , хэрэгжүүлэх, Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, хамтран суралцах чадварт суралцуулах зорилготой “САЙН ХИЧЭЭЛ” үйл ажиллагаа зохион байгуулагдаж, нийт 29 багш 7 баг болон оролцсоноос “Уран зохиол” суурьтай нийгмийн ухааны хичээлийг интеграцчилан МХБУЗ-ын багш Б.Дуламсүрэн, ТНУ-ы багш Б.Мөнхзаяа, МХБУЗ-ын багш Э.Будмаа нарын бэлдсэн Бямбын Ринченгийн “Нууцыг задруулсан захиа” сэдэвт 9-р ангийн хичээл ТЭРГҮҮН байр, “Хүн ба байгаль” суурьтай бага, дунд ангийн байгалийн ухааны хичээлийг интеграцчилан Химийн багш Ц.Туул, Газарзүйн багш Б.Даваасүрэн, Математикийн багш С.Цэрэнбүтэд, Математикийн багш А.Цэнджав нарын бэлдсэн “Байгаль дээрх ус хэрхэн хувирдаг вэ?” сэдэвт 5-р ангийн хичээл ДЭД байр, “Хүн ба орчин” суурьтай бага ангийн байгалийн ухааны хичээлийг интеграцчилан Бага ангийн багш Б.Дэлгэрцэцэг, М.Өсөхжаргал, А.Сувд-эрдэнэ, Ч.Бурмаа, Б.Ангарагмаа нарын бэлтгэсэн “Сарууд хэд хоногтой байдаг вэ?” сэдэвт 2-р ангийн хичээл ГУТГААР байранд тус тус шалгарсан байна. “Интеграцид суурилсан багшлахуй ба суралцахуй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын 2-р шатанд нийт 18 сургууль оролцсоноос Э.Дондог, Б. Мөнхсайхан багш нарын “Туршилтат арга зүйг интеграцлах нь” сэдэвт илтгэл 5-р байранд шалгарсан.	100						
21	АХ-1.2.2.2	Багш, удирдах ажилтны нийгмийн баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.	Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа	тоо	2024	1	Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг их, дээд сургуульд тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр үнэгүй сургах гэсэн заалтын дагуу хүүхдийн цэцэрлэгийн 1 багшийн хүүхдийн сургалтын төлбөрийг жил бүрийн төсөвт суулган сургаж байна. Цэцэрлэгийн багш, ажилчдад улирлын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэлийг журмын дагуу олгож, эхний хагас жилийн байдлаар 4,2 сая төгрөг, ЕБС-ийн багш, ажилчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу 33,6 сая төгрөгийн дэмжлэг, тэтгэмж, урамшууллыг тооцож олгосон байна.	80	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ	
			Дэмжлэг, урамшуулалд хамрагдсан албан хаагч	тоо	2024	5	5	Дэмжлэг үзүүлсэн албан хаагч байхгүй. Нийт 72 төрийн албан хаагчид улирлын урамшууллыг олгосон.	80	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Зарцуулсан хөрөнгө	сая.төг	2024	-	33.6	Нийт урамшуулалд 37.8 сая төгрөгийг зарцуулсан.	80.0	33.6	33.6	100	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
22	АХ-1.2.2	Ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Тоо	2024	-	5	Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сурагчдын аюулгүй байдлыг хангах, хүүхдээ зөв хүмүүжүүлэх арга зэрэг зөвлөмжүүдийг видео болон цаасан хэлбэрээр бэлтгэн эцэг эхчүүдэд хүргэсэн. Сурагчдад зөв хүмүүжил төлөвшилийг бий болгох зорилго бүхий “ТАЛАРХЛЫН АЯН”-ны хүрээнд “Цэвэр цэмцгэр орчинд сурах нөхцлийг бүрдүүлж өгдөг үйлчлэгч нартаа талархлаа”, “Үргэлж амттай хоолоор үйлчилдэг тогооч нартаа талархлаа” аяныг зохион байгуулсан. “Хүүхдээ сонсох өдөр”-ийг 1 удаа зохион байгуулж, 5-12 дугаар ангийн 32 сурагчийн төлөөлөл оролцсон. Сурагчдаас ирсэн санал санаачлагыг сургуулийн “Хүүхэд хамгааллын баг”-аар хэлэлцэн үе шаттайгаар шийдвэрлэн ажилласан. Эцэг эх, асран хамгаалагч,нарыг хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцуулах, багш нараас зөвлөгөө авах ажлыг 1 удаа зохион байгуулсан.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
23	АХ-1.2.3.1	Засгийн газар болон дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, дэд хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.	Англи хэлний сурлагын чанар	хувь	2024	41	45	Нийт сурагчдын “Англи хэлний” сурлагын чанар 43.5% болж, өмнөх оноос 2.5 хувиар нэмэгдсэн.	90	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Математикийн сурлагын чанар	хувь	2024	35	37	Нийт сурагчдын “Математик”-ийн сурлагын чанар 37% болж, өмнөх оноос 2 хувиар нэмэгдсэн.	100	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Мэдээлэл зүйн сурлагын чанар	хувь	2024	50	55	Нийт сурагчдын Мэдээлэл зүйн сурлагын чанар 50-54% болж нэмэгдсэн байна.	90	-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
			Хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	2024	0	75	Хугацаа болоогүй.		-	-	-	ЕБС, цэцэрлэг	ЗДТГ
24	АХ-1.2.3.2	Сургуулийн өмнөх боловсролд шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи, уран бүтээл хийх, амьдрах ухаан, ур дүй хөгжүүлэх STEAM үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Бүлгийн тоо	тоо	2024	0	2	2025 оны хагас жилийн байдлаар 5 бүлэгт Steam хөтөлбөрийг нэвтрүүлж эхлээд байна. Steam хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг дарга 13 ширхэгтэй, 1 багц тоглоомыг хүлээлгэн өгсөн. Цаашид 6 багц тоглоом авах хүсэлтийг сумын Засаг даргад хүргүүлээд байна.	100	3 сая	3 сая	100	Цэцэрлэг	ЗДТГ

25	AX-1.2.3.5	Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог улсын дунджаас нэмэгдүүлнэ.	ЭЭШ-ийн судлагдахуун бүрийн дундажаар хэмжинэ.	тоо	2024	507	509	2025 оны элсэлтийн ерөнхий шалгалтын судлагдахуун тус бүрийн дундаж оноо Англи хэл 485, Хими 528.1, Нийгэм судлал 451.8, Биологи 488, Математик 476.6, Физик 448.3, Монгол хэл 590.6-тай байна	100	-	-	-	ЕБС	ЗДТГ
26	AX-1.2.3.6	Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс суманд нэн шаардлагатай мэргэжлээр хүүхдүүдийг сургах, дэмжлэг	Дотоодын тэтгэлэгт хамрагдсан оюутан	Тоо	2024	2	1	Тэтгэлэгт хамруулах хугацаа болоогүй	90	-	-	-	ЕБС	ЗДТГ
			Гадаадын тэтгэлэгт хамрагдсан оюутан	Тоо	2024	1	1	Тэтгэлэгт хамруулах хугацаа болоогүй	90	-	-	-	ЕБС	ЗДТГ
27	AX-1.2.3.7	Бүх насны иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, хөгжих боломжийг бүрдүүлнэ.	Боловсрол нөхөн олгосон хүний тоо	тоо	2024	бүрэн дунд-1	бүрэн дунд-2	Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 2 иргэн бүрэн дунд боловсрол эзэмшихээр суралцаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд 1 иргэн төгс, бүрэн дунд боловсролын гэрчилгээгээ гардан авна.	100	-	-	-	ЕБС	ЗДТГ
БОЛОВСРОЛЫН ЗОРИЛТЫН ДУНДАЖ									91					
Нэг. Хүний хөгжлийн бодлого														
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн														
Гэр бүл, хүүхэд, залуучууд														
28	AX-1.3	Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулж, бие болоод сэтгэл зүйн хувьд эрүүл хүүхдийг төлөвшүүлэн, эх оронч үзэлтэй, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан, нийгмийн идэвхтэй шинэ үеийн залуучуудыг бэлтгэнэ.	Хамрагдсан иргэдийн хувь	Хувь	2024	49.6	55	2025 оны эхний хагас жилийн байдлаар гэр бүл, залуучууд, хүүхдэд чиглэсэн 20 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 1491 иргэнийг хамруулсан байна.	100	-	-	-	НБМ, ХГБНА	ЕБС, ТАХ-д
Хөтөлбөрийн үр дүн														
Хүүхэд, гэр бүл, залуучууд														
29	AX-1.3.2	Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хөгжил оролцоонд хамрагдсан нийт гэр бүлийн тоо	Тоо	2024	113	120	Хагас жилийн байдлаар Гэр бүлийн боловсрол олгох сургалт 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 104 иргэн, сурагч хамрагдсан байна. Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн үнэ цэнэ сэдвээр 2 гэр бүлд сургалт хийн, анхан шатны сэтгэлзүйн явуулын үйлчилгээ болон ганцаарчилсан үйлчилгээ үзүүлсэн.	90	-	-	-	НБМ, ХГБНА	ТАХ-д
30	AX-1.3.1	Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжил оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.	Хөгжил оролцоонд хамрагдсан нийт хүүхэд, залуучуудын тоо	Тоо	2024	250	300	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Хүүхдэд ээлтэй орчин сургалт нөлөөллийн ажлыг ЭМТ, хэсгийн төлөөлөгч, ЕБСургууль, соёлын төвтэй хамтран зохион явуулсан. Сургалтад давхардсан тоогоор 74 хүүхэд хамрагдсан. Мөн ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчдад газар хөдлөлтийн аюулаас урьлчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, "СУУ-НУУГД-ХҮЛЭЭ" дүрмийн дагуу дадлага сургуулилтыг зохион байгуулсан.	90	-	-	-	НБМ, ХГБНА	ТАХ-д
31	AX-1.3.1	Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, хөгжил оролцоог нэмэгдүүлнэ.	Хөгжил оролцоонд хамрагдсан нийт залуучуудын тоо	Тоо	2024	780	900	Сумын хэмжээнд 15-34 насны 800 залуучууд байна. Үүнээс 384 эмэгтэй, 416 эрэгтэй байна. Залуучуудын дунд 3 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 178 залуучууд, 5 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 624 иргэнийг хамруулан 3,994,500 төгрөг зарцуулсан байна.Олон улс болон аймгийн чанартай 2 удаагийн тэмцээн уралдаанд 7 залууст 630,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 12 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, сумын нийт залуучуудын 59 хувийг хамруулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 66,6 хувь байна.	100	4.6 сая	4.6 сая	100	НБМ	ТАХ-д
32	AX-1.3	Нийгмийн бүлгүүдийн хөгжил оролцоог нэмэгдүүлнэ.	Хөгжил оролцоонд хамрагдсан нийгмийн бүлгийн тоо	Тоо	2024	850	700	Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур, Булган сумын ахмадуудын дунд "ДҮРСАМЖ УУЛЗАЛТ 2025" нөхөрсөг Спортын тэмцээн болон Дуун цэнгүүн зохион байгуулагдаж, нийт 77 ахмад хамрагдсан байна. Тэмцээний шагналын зардалд 650,000 төгрөг зарцуулсан. Рашаант суманд зохион байгуулагдсан "Дашинчилэн-Рашаант сумын ахмадууд – бид үе тэнгийнхэн" спортын нөхөрсөг уулзалт тэмцээнд тус сумаас 14 ахмадууд оролцож, тэмцээний бооцооны мөнгө болон шатахууны зардалд 375,000 төгрөг зарцуулсан. Сар болгон ахмадын дуун цэнгүүн, софт волейболын тэмцээн зохион байгуулагдаж хэвшсэн. Дээрх үйл ажиллагаанд хагас жилийн байдлаар 511 ахмад хамрагдсан байна.	80	1.2 сая	1.2 сая	100	НБМ	ТАХ-д
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа														
Хүүхэд, гэр бүл, залуучууд														
33	AX-1.3.2.1	Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээний тоо	Тоо	2024	3	4	Гэр бүлийн боловсрол олгох "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга" сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулсан.	50	-	-	-	ХГБНА	НБМ, БЗД нар
			Хамрагдсан иргэд	Тоо	2024	150	200	Давхардсан тоогоор 84 хүн хамрагдсан.	50	-	-	-		

34	AX-1.3.2.1	Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж гэр бүлийн хүчирхийллийг бууруулна.	Гэр бүлийн хүчирхийллийн тоо	Тоо	2024	3	4	Аймгийн ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу сумын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Булган аймгийн урд бүсийн СӨБ-ын байгууллагуудын дунд “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЦАГААН ТОЛГОЙ” урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг сумандаа зохион байгуулсан. Тус нөлөөллийн арга хэмжээнд Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант сумын СӨБ-ын 40 хүүхэд, 8 багш, 16 эцэг эхийн төлөөлөл оролцсон. ГХЗУСАЗСЗ-тэй хамтран Хүүхэд, Гэр бүл хөгжил хамгааллын сэтгэлзүйчийг суманд ажиллуулж, сэтгэлзүйн анхан шатны ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг 8 хүүхэд, 26 насанд хүрэгчдэд өгч, эрсдэлт нөхцөл дэх айл, архины хамааралтай иргэдтэй уулзан явуулын үйлчилгээ үзүүлсэн	80	-	-	-	ХГБНА	НБМ, БЗД нар
35	AX-1.3.1	Хамтарсан багийн чадавжуулах замаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.	Төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	85	90	Сумын хамтарсан багийн гишүүдийг аймгийн ХГБХХГ, МИГ даатгалтай хамтран зохион байгуулсан “Хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах” сургалтад хамруулсан. Хамтарсан багийн тайланг хагас жилийн байдлаар 2 удаа аймгийн ХГБХХГ-т хүргүүлсэн. 2025 оны хагас жилийн байдлаар Хүүхэд хамгааллын зардалд 27,000 төгрөг, хүүхдийн хөгжлийн чиглэлээр 738,600 төгрөг, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр 77,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус зарцуулсан байна. Хагс жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна	90	-	-	-	ХГБНА	Хамтарсан баг
36	AX-1.3.1.2	Иргэн, хувийн хэвшлийн санаачилгатай хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн секц дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг	Секц дугуйлангийн тоо	Тоо	2024	12	15	2025 оны хагас жилийн байдлаар Ерөнхий боловсролын сургуульд 12 төрлийн 16 дугуйланд эрэгтэй 95, эмэгтэй 164, нийт 259 сурагч, Соёлын төвд морин хуур, амьд хөгжмийн дугуйланд 31 хүүхэд хамрагдаж байна.	90	-	-	-	СТ, ЕБС, ХГБНА	ТАХ-д
			Хамрагдсан хүүхэд	Тоо	2024	200	250	290 хүүхэд хамрагдсан байна.	100	-	-	-		
37	AX-1.3.1	Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автах аас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	Тоо	2024	3	4	Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Утаат болон электрон тамхины хор хөнөөл, үр дагавар”, “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдвээр 1 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн дээрх сэдвийн хүрээнд Дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, 30 сурагч хамрагдсан. ЕБСургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Цахим орчны зохистой хэрэглээ” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж, 14 сурагч хамрагдсан.	90	-	-	-	ХГБНА, НБМ	БЗД нар
			Хамрагдсан хүүхэд	Тоо	2024	155	200	Осол гэмтэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажилд 116 хүүхэд хамрагдсан.	80	-	-	-		
38	AX-1.3.1.1	Өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, сонирхолтой өнгөрүүлэх, идэвх, оролцоог дэмжих “Залуусын хөгжил” хөтөлбөрийг сумын хэмжээнд хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	2024	0	70	Хугацаа болоогүй	-	-	-	-	НБМ	БЗД нар
39	AX-1.3.1.2	Өсвөр үе хүүхэд залуучуудад чиглэсэн олон талт тэмцээн уралдаан, сургалт, нөлөөллийн ажлын тоог нэмэгдүүлнэ.	Арга хэмжээний тоо	Тоо	2024	10	15	Залуучуудын дунд 8 удаагийн сургалт нөлөөллийн ажил, 7 удаагийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Мөн ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ЕБС, цагдаагийн хэсэг, ЭМТ-тэй хамтран “Хүүхдэд ээлтэй орчин” сэдэвт сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Булган аймгийн урд бүсийн сумдын сургууль, Булган аймгийн хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран бүсийн зөвлөгөөнийг зохион явуулсан. Зөвлөгөөнд 90 хүүхэд, 6 насанд хүрэгч оролцсон.	100	-	-	-	НБМ	ЕБС, СТ, ХГБНА, БЗД нар
			Хамрагдсан иргэд	Тоо	2024	1750	2000	1096	50	-	-	-		
40	AX-1.3.2.2	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн /эрэгтэй, эмэгтэй/ эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил	Тоо	2024	3	5	Жендэрийн дэд салбар хороог 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Хорооны гишүүдээс “Ажлын байрны жендэрийн мэдрэмжийг үнэлэх” асуудлыг шалгуур үзүүлэлтийн дагуу авсан. Мөн “Харилцан хүндэтгээ” сарын аяны хүрээнд 7-9 дугаар ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээнийг Жендэр, Гэр бүлийн хүчирхийлэл, Архи, Тамхи, Электрон тамхи, Үе тэнгийн дээрэлхэлт гэсэн урьдчилан бэлтгэсэн сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Тус тэмцээнд 5 багийн 30 сурагч хамрагдсан. Тэмцээний шагналын зардалд ОНХС-аас 240,000 төгрөг зарцуулсан байна. Мөн аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Жендэр” сэдэвт цахим сургалтад сум, сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн хамрагдсан.	50	-	-	-	НБМ	ЗДО
ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ЗАЛУУЧУУД ЗОРИЛТЫН ДУНДАЖ									80.6					

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО														
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн														
Хөдөлмөр эрхлэлт														
41	АХ-1.4	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлыг байрыг бий болгож, ажилгүйдлийн түвшинг бүрүүлнэ.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	2023	10.8	10.6	Сумын хэмжээнд хөдөлмөрийн насны 1536 иргэн байгаагаас ажил хөдөлмөр эрхэлж байгаа 1375 иргэн буюу 89.5% нь ажил хөдөлмөр эрхэлж байна.	100	-	-	-	ХЭХАХМ	БЗД нар
Хөтөлбөрийн үр дүн														
Хөдөлмөр эрхлэлт														
42	АХ-1.4.1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.	Өрхийн амьжиргааны баталгаажих түвшин	Хувь	2024	11.3	11.1	Сумын хэмжээнд 915 өрх байгаагаас амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 102 өрх байна. Халамжаас-Хөдөлмөрт зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025-2028 онд хөгжүүлэх 20 өрхийг сонгон төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 61.3 хувьтай хэрэгжиж байна.	100	-	-	-	ХЭХАХМ	БЗД нар
Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа														
Хөдөлмөр эрхлэлт														
43	АХ-1.4.1.1	Засгийн газар болон дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Хувь	2024	-	70	Хугацаа болоогүй		-	-	-	ЗДО, ХЭХАХМ	БЗД нар
44	АХ-1.4.1.2	Үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд 150-аас доошгүй байнгын болон улирлын чанартай ажлын байрыг бий болгоно.	Шинээр бий болсон ажлын байр	Тоо	2024	45	66	Хагас жилийн байдлаар шинээр байнгын ажлын байранд 30, улирлын ажлын байранд 1, түр ажлын байран 1, нийт 32 ажлын байр бүртгэсэн байна.	80	-	-	-	ЗДО, ХЭХАХМ	ХЖДҮХАХМ
45	АХ-1.4.1.3	Халамжаас хөдөлмөрт шилжиж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангаж, төсөл хөтөлбөрт хамруулна.	Сургалтанд хамрагдсан иргэн	Тоо	2024	-	20	Халамжаас-Хөдөлмөрт шилжих 20 өрхийн 5 иргэнийг төсөл бичих сургалтад, хөдөлмөр эрхлэх сургалтад ажил хөдөлмөр эрхлээгүй 8 иргэнийг тус тус хамруулсан.	80	-	-	-	ХЭХАХМ	БЗД нар
			Ажлын байранд зуучлагдсан иргэн	Тоо	2024	5	8	Халамжаас-Хөдөлмөрт хөтөлбөрийн хүрээнд "Зөв 20" өрхийн 5 гишүүнийг байнгын ажлын байранд зүүчилсан.	100	-	-	-	ХЭХАХМ	БЗД нар
			Дэмжлэгт хамрагдсан иргэн	Тоо	2024	13	15	ХЭДС-аас зарлагдсан малжуулах төсөл хөтөлбөрт 4 өрх хамрагдаж 32 сая төгрөг, ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 4 иргэн хамрагдаж 32 сая төгрөг, иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж 10 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн хамрагдаж 16 сая төгрөгийн зээлийг тус тус авсан байна.	100	90 сая	90 сая	100	ХЭХАХМ	БЗД нар
